



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 8/431

Арвайхээр

### Коронавируст халдварт (COVID-19)-тай иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх түр ор дэлгэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06 сарын 28-ны өдрийн “Коронавируст халдварт (COVID-19)-ын үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай” А/416 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (COVID-19)-ын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан Хархорин суманд коронавируст халдварт (COVID-19)-тай иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орны тоог хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдварт (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээ, халдвартын сэргийлэлтийн холбогдох журам, зааврын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг ханган ажиллахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг (Д.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүй, хүний нөөцийн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун) нарт тус тус даалгасугай.

4. Хархорин сумын Энэрэл-Хархорин өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, нүүлгэн шилжүүлэх ажлыг богино хугацаанд шийдвэрлэн, коронавируст халдварт (COVID-19)-ыг эмчлэх ор дэлгэхийг Хархорин сумын Засаг дарга (Ч.Алтанбагана)-д даалгасугай.

5. Коронавируст халдварт (COVID-19)-ын хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой зардлыг холбогдох тушаал, журмын дагуу хянаж ор дэлгэн ажиллуулсан өдрөөс эхлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (Энхжаргал)-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011100917

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны .....  
дугаар сарын .....-ны өдрийн .....дугаар  
захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД  
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ОРНЫ ТОО

№	Сумын нэр	Дэлгэх орны тоо	Байгууллагын нэр	Үндсэн орны тоо
1	Хархорин сум	43	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн дотор, хүүхдийн тасаг	40
2	Хархорин сум	33	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн халдвартын тасаг	15
3	Хархорин сум	50	Хархорин сумын Энэрэл-Хархорин өрхийн эрүүл мэндийн төвийн байр	-
		126		

-оOo-

